



## ДУГНЭЛТ

### **С.Баттулга**

*Монголын Япон хэлний Багш нарын холбооны  
Удирдах зөвлөлийн гишүүн,  
Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцаа,  
Нийтийн Удирдлагын Сургуулийн захирал*

Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Би Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Ази судлалын тэнхимд япон судлалын профессорын багт харьяалагддаг. Мөн Монголын Япон хэлний багш нарын холбоонд багтдаг хүн юм. Хоёр чиглэлээр товч үг хэлье. Нэгдүгээрт, хурлын ач холбогдол юу байв, хоёрдугаарт, бидэнд ямар асуулт гарав, бид юунд анхаарах вэ? гэдэг талаар өөрийн бодлыг хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, өнөөдрийн хурлын ач холбогдлыг цаг үеийн байдалтай холбож хэлэхийг хүсэж байна. Өнөөдөр бид “Корона 19” гэгдэх шинэ төрлийн цар тахалтай нүүр тулаад байна. Нийтээрээ хөл хорионд орж, олон асуудалтай тулгарч байна. Нэн ялангуяа боловсролын байгууллагууд, хүүхдүүд цахимаар хичээллэж, цахим сургалт явагдаж байна. Корона нийгэм, эдийн засаг, олон улсын харилцаа, мөн түүнчлэн хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлж болох талаар, цаашид үүсэх эдийн засгийн бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар ярьж хэлэлцэж байгаа онцгой цаг үед бид энэхүү хурлаа маш амжилттай зохион байгуулж байна гэдгийг онцлон хэлмээр байна. Мөн Монгол, Японы харилцааны чухал он жил ойртож байна. 2022 онд Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой болно. Энэ ойг угтаж, бид монгол дахь япон хэлний сургалтыг хэрхэн шинэ шатанд гаргах тухай асуудалд анхаарал хандуулсан ажил хэрэгч хурал боллоо. Хамгийн чухал хэлэх зүйл бол Монгол улсад Япон хэлний боловсрол үүсэж хөгжсөний 45 жилийн ой тохиож байгаа энэ цаг үед энэ хурал болж байгаагаараа их онцлог гэж хэлмээр байна.

Энэ симпозиум 13 дахь жилдээ болж байна. Монголын Япон хэлний багш нарын холбоо, Монгол Улсын Их Сургуулийн Ази судлалын тэнхим, тэр дотроо япон хэлний багш нар Монгол-Япон төвтэй хамтран, Монгол улс дахь Япон улсын ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр зохион байгуулж ирсэн. Үүнийг шинээр оролцож байгаа хүмүүст сануулж хэлэхийг хүсэж байна.

Хурал маш сонирхолтой боллоо. Учир нь, симпозиум болгоны үндсэн илтгэгч тухайн чиглэлээрээ мэргэшсэн хүн байдаг. Үүнийг манай япон хэлний багш нар маань эрэл хайгуул хийж, хөөцөлдөж, монголын япон хэлний багш нарынхаа чадварыг сайжруулах юмсан, үйл ажиллагааг нь дэмжих юмсан, шинэ санаа өгөх юмсан гэсэн зорилго тавьж ажилладаг. Өнөөдрийн үндсэн илтгэгч ШИНЗАКИ профессор Япон улсдаа үнэхээр мэргэжлийн түвшний судлаач хүнээс гадна орчуулга, хэлмэрчлэхүйн салбартаа нэр хүндтэй, туршлагатай хүн гэдэг

нь их олзуурхуштай байна. Би ч бас энэ хүний лекцийг сонсоод их зүйлийг сурч мэдэж авлаа. Энэ бол бид хамтаараа олж авсан мэдлэг юм. Энэ илтгэлүүд дотроос зарим зүйлийг эргэн нэг санах хэрэгтэй болов уу гэж бодож байна. Илтгэлүүд хэлмэрчлэхүй, орчуулахуйн суурь ойлголтуудыг эргэн харах боломжийг бидэнд олголоо. Түүнээс гадна хэлмэрч, орчуулагч хүний үүрэг гэж юм байдгийг эндээс санаж авлаа. Хүн эх хэлээрээ өөрийнхөө санааг илэрхийлэх эрх хүнд байдаг. Хэлмэрчлэхүй, орчуулахуйд өөрийн эх хэл гэдэг их чухал юм гэдгийг дахин ойлгож авлаа. Мөн ямар зорилгоор, хэнд хандаж, юуны төлөө орчуулга, хэлмэрчлэхүй хийх гэж байгаа билээ гэдгээ санах ёстойг ойлгуулсан сайхан илтгэлүүд боллоо. Нөгөө талаас манай 7 илтгэгч маань гайхамшигтай туршлагатай, гайхалтай хэлний мэдлэгтэй хүмүүс байлаа. Миний үеийн найз нөхөд, хамт сургууль төгссөн, олон жилийн өмнөөс нэгнийгээ сайн мэдэх хүмүүс ирсэнд би их баяртай байна. Энэ хүмүүс япон хэлнийхээ чиглэлээр ч тэр, сургуулиа төгсөөд орчуулга, хэлмэрчлэх гэдэг чиглэлээр монгол залуучууд дундаа их туршлага хуримтлуулсан хүмүүс байгаа юм гэдгийг би энд онцолж хэлмээр байна. Энэ нь манай хурлын мэдлэгийн түвшин, ач холбогдлыг өргөж өглөө гэж хэлмээр байна. Түүнээс гадна илтгэгч нар маань илтгэлээ маш сайн бэлдсэн, маш их статистикийн болон агуулгын мэдээлэлтэй сайхан илтгэлүүд байлаа. Өөрөөр хэлбэл мэргэжлийн их олон талын оролцоог хангасан үр өгөөжтэй хурал боллоо гэж би дүгнэж хэлмээр байна. Нэг зүйлийг нэмж цохон тэмдэглэхэд цахим хурлын технологийг бид энэ удаа ашиглаж үзлээ. Корона бидэнд ийм боломж олгох шиг боллоо. Цаашдаа бид үүнийг илүү түлхүү ашиглах ёстой гэж бодож байна. Хурал монгол хэл дээр явагдлаа. Өмнө ихэнхдээ япон хэл дээр явагддаг байсан. Япон багш нар их байсан учраас тэгдэг байсан байх. Гэхдээ монгол хэлээр явуулах нь зүйтэй юм. Хэрэгтэй, шаардлагатай үед орчуулгыг зохицуулж явах ёстой юм байна.

Хурлыг ерөнхийд нь дүгнэж хэлэхэд, нэгдүгээрт, маш сонирхолтой, өндөр түвшинд зохион байгуулагдсан хурал боллоо гэж дүгнэж хэлмээр байна. Хоёрдугаарт, би өөрийн хэмжээнд ойлгосон зүйл дээрээ тулгуурлаад хэд хэдэн зүйлийг хэлье. Бид орчуулахуй, хэлмэрчлэхүй гэж юу вэ гэдэг асуултыг өөртөө байнга тавьж байх ёстой юм байна. Энэ нь их цогц ажил юм байна. Цогц ажлын бүрдэл болсон процесс юм байна гэж надад ойлгогдож байна. Би их сургуульд байхдаа орчуулгын хичээл заалгаж л байсан, зааж ч байсан. Түүнээс хойш ч орчуулгын олон ажилд оролцож явлаа. Богино хугацаанд, олон судалгаа хийж, зөв ойлголтод тулгуурлан хийх ёстой ажил юм байна. Нөгөө талаар харилцааны асуудал юм байна. Хоёр тал хувь хүмүүсийн хоорондох, эсвэл улс үндэстний хоорондох харилцааны асуудал юм байна. Мөн соёлын ойлголт, соёлын харилцааны асуудал юм байна. Түүнээс гадна боловсролын тогтолцооны, хөтөлбөрийн, заах аргын, агуулгын чанарын асуудал юм байна. Энэ нь бидний туршлага, техникийн дэвшил, багшийн чадамжийн тухай асуудал юм. Мөн сонирхол, хүсэл эрмэлзлийн асуудал юм байна. Суралцагч маань хэр хүсэл сонирхолтой суралцаж байна вэ? Тэдний суралцах эрмэлзлэлийг хэрхэн яаж өдөөх вэ? Энэ их чухал юм байна. Эх хэлний асуудал мөн яригдана. Хэлийг нэг нэгэндээ туслах гэдэг сэтгэлээр үзэх ёстой юм байна. Үүнийг цаана өөрийнхөө хэл соёлоор бахархах, бусдын соёлыг хүндэтгэх гэдэг агуулга явж байгаа юм байна. Мөн хэл хэлмэрчлэхүй, орчуулахуй багийн ажил гэдэг ойлголт явж байна. Нэг хүний хувийн ажил юм шиг мөртлөө цаанаа их том, өргөн агуулгатай ажил гэдгийг бид мэдэж авлаа. Мэдэж байгаа л даа, гэхдээ бид цэгцтэй ойлголтыг авлаа. Соёлын орчуулга гэж байдаг. Ялангуяа соёлын антропологичидын дунд соёлыг хэрхэн орчуулах, хэрхэн буулгах, дамжуулах вэ гэдэг асуудал. Энэ нь цаанаа нэг үгийг орчуулах ажил биш, түүний нюанс, мэдрэмж, тухайн цаг үеийн нөхцөл байдал, ялангуяа олон улсын харилцаанд дипломатч хоорондын гэрээ хэлэлцээр хийх эгзэгтэй цаг мөч, нэн ялангуяа дайны байдалтай

цаг үе гэх мэт зүйлүүд бий. Ийм үед орчуулагч хүн маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийм л ажил гэж бодож байна.

Үүнээс улбаалаад өнөөдөр бидэнд ямар асуудал тулгарч байгаа вэ гэдэг асуулт зүй ёсоор урган гарч ирнэ. Би өнөөдөр илтгэгчдийнхээ илтгэлээс асуултуудыг хайх гэж оролдлоо. Эцэст нь бид наймаачны орчуулагчийг олноор бэлдэж иржээ. Энэ түвшинг ахиулах цаг нь болжээ. Дараагийн мэргэжлийн түвшин рүү дахиад нэг шат алхацгаая, гэдэг санаа бууж байх шиг. Мөн орчуулах, хэлмэрчлэх хичээлийг сонирхон сонгож байгаа оюутны тоо буурч байгаа асуудал анхаарал татлаа. Мөн эх хэлний чанарын асуудал тавигдаж байна. Түүнээс гадна ийм мэргэжлийн зах зээл байна уу? Тийм олон хүнийг бэлдэх ёстой юм уу? гэдэг асуулт гарч байна. Эдгээр асуудлуудыг би өнөөдөр илтгэгчдийнхээ илтгэлүүдээс олж авлаа.

Үүнээс улбаалаад цаашид бид орчуулах, хэлмэрчлэхүйн талаар, ялангуяа боловсрол сургалтын хувьд юуг анхаарах ёстой вэ? Энэ талаар өөрийн бодлыг хэлье. Бид юуны төлөө хэлмэрч, орчуулагч хүнийг бэлтгэх гээд байгаа юм бэ? гэдэг асуултыг та нарт тавимаар байна. Юуны төлөө бэлдэх гээд байгаа юм бэ. Үүнийг нэгд, хувь хүний асуудал гэх байх. Хоёрт, улс үндэсний асуудал юм. Хувь хүн гэдэг дээр би монгол хүний чадамжийн асуудлыг хөндөх гээд байна. Монгол хүн бүр хөрвөх өндөр чадамжтай, авьяас ур чадвартай, мэдрэмжтэй байх ёстой. Ямар ч тохиолдолд юманд баригдахгүй, анализ хийж чаддаг, логиктой ойлгодог байгаасай. Энэ шаардлага бидний амьдарч байгаа орчны нөхцөл байдалтай уялдаатай. Ийм л хүнийг бэлдэхгүй бол бид байхгүй болно гэсэн хагуухан ойлголт надад байгаа юм. Бид олон хэлийг мэддэг, ойлголцож чаддаг үндэстнийхээ соёл туршлагаас суралцдаг байх хэрэгтэй юм. Энд би япон хэл их чухал юм гээ хэлэх гээд байна. Хоёрдугаарт, улс үндэстний эрх ашгийн асуудал заавал яригдах ёстой юм. Би өнөөдөр олон улсын харилцаа, нийт удирдлагын сургуулийн захирлаар ажиллаж байна. Ийм мэдрэмж их төрдөг юм. Өөрөөр хэлбэл улс орны эрх ашиг их чухал байна. Бид хоёр том гүрний дунд байдаг. Энэ хоёр том гүрэн маань маш их амбицтай, дэлхийд нөлөөлөх чадалтай. Том амбиц бүхий энерги ялгаруулж байгаа улсуудын дунд бид өөрийн эрхгүй татагдан автаж, аяндаа уусах, ийм нөхцөл байдалд бид байгаа юм. Тэгэхээр бид гурав дахь, дөрөв дэх соёл, үндэстэнтэй ойртох ёстой юм л даа. Энэ бол бид өөрсдийнхөө соёлыг урт хугацаанд хадгалж чадах уу? Энэ утгаараа монголчууд “гуравдагч хөрш” гэдэг ойлголтыг дипломат бодлогодоо гаргаж ирсэн юм. Түүхэн уламжлалаараа, монголчуудын зүрх сэтгэлээс урган гарсан зүйл явсаар гуравдагч хөрш гэдэг ойлголтыг бий болгосон гэж хэлж болно. Манайх Ази дотроо Япон улсыг сонгосон байдаг юм. Бид японтой илүү их түншлэх ёстой юм. Манай монголын хөгжлийн онцлогоос хамаарч тэргүүн эгнээнд хөгжүүлэх ёстой салбарууд гэж байдаг. Энэ талаар бид японтой хамтарвал илүү амжилтад хүрэх болно. Сүүлийн үед хятад хэл, англи хэлийг сонирхдог хүн эрс нэмэгдэж байна. Үүнд болгоомжилж хандах биш, харин монгол хүн хоёр гурван хэлийг зэрэг сурах технологийг бий болгох хэрэгтэй гэж бодож байна. Хятад хэлтэй, бас япон хэлтэй байж болно. Англи хэлтэй, бас япон хэлтэй байж болно. Бид ийм зүйлийг бодох ёстой. Мэдээж дэлхийн чиг хандлагыг харгалзах ёстой.

Коронагийн үед бид гадаад хэлийг хэрхэн яаж сурах вэ, орчин үеийн мэдээллийн технологийг яаж түлхүү ашиглах вэ, энэ талаар нарийн арга зүй бидэнд их чухал байна. Орчин үед залуучуудын гадаад хэл сурах арга барил маш их өөрчлөгдөж байх шиг байна. Бидний үеэс одоогийн залуучууд өөр хурдаар сурч байна. Үүнийг зайлшгүй бодолцох болсон байна. Эндээс үүдээд япон хэлний багш нарын сургалтын байгууллагуудын үүрэг юу вэ? Бид яаж үүнд оролцох вэ? гэдэг асуулт урган гарч ирэх байх. Монгол хүний чадамжийн талаас бодвол

массада чиглэсэн сургалт зайлшгүй шаардлагатай. Хүмүүс өөрийн хүсэл сонирхлоороо сурч болно. Боловсролын байгууллагыг сонгож болно, зурагт үзээд сурчаж болно. Энэ бол массын, хувь хүний өөрсийн чадавхаа дээшлүүлж байгаа сургалтын нэг арга хэлбэр. Үүн дээр онлайн хэрэгтэй болно. Үүний зэрэгцээ цөөн тоогоор мэргэжлийн орчуулагчийг бэлдэх асуудал өнөөдөр Монгол улсад тулгамдаж байна. Ялангуяа гадаад харилцааны салбарт энэ асуудал маш тулгамдсан асуудал болжээ. Маш олон мэргэжлийн түвшинд орчуулдаг мэргэжилтнийг яаралтай бэлдэх хэрэгцээ шаардлага тулгарчихсан байна. Өнөөдөр улс хоорондын эрх ашиг хөндөгдсөн гэрээ хэлэлцээр ихээр байгуулагдаж байгаа тул мэргэжлийн орчуулагч нарын үүрэг маш чухал болчихоод байгаа. Энэ өрөөнд юу болоод байна вэ гэдгийг эхний ээлжид зөв мэдэрч ойлгож чаддаг, тухайн хэлээр хоёргүй утгаар ойлгуулж чаддаг хүн хэрэгтэй байна шүү дээ. Маш их мэдлэг, маш их туршлага хэрэгтэй байна бидэнд. Тийм учраас бид хэлмэрчлэхүй, орчуулахуйн ажилд өөр өнцгөөс хандах шаардлага үүссэн байна. Олон хэлний хэлмэрчдийг бэлдэж байгаа багш нар, судлаачдын хамтын ажиллагаа их чухал болж ирлээ. Суурь мэдлэгийг хэрхэн яаж цэгцтэй өгөөд, дараа нь яаж өөрийн онцлогоо тусгах вэ? гэдэг их чухал байна. Тийм учраас цөөн тоогоор өндөр түвшний мэргэжилтэн бэлдэх шаардлага бид нарт байна аа гэж үзэж байна. Өнөөдөр хэлмэрчлэхүй, орчуулахуйн хичээл дээр багаар хэрхэн ажиллах, мөн толийг хэрхэн яаж богино хугацаанд зөв ашиглаж сурах вэ гэдэг аргачлал чухал гэж бодож байна. Энэ мэт зүйлүүдийг бид цаашдаа анхаарч, сургалтын үйл ажиллагаандаа, туршлага солилцох хамтын ажиллагаандаа ашиглах ёстой юм байна гэдгийг онцлон хэлэхийг хүсэж байна.

Эцэст нь хэлэхэд хурлынхаа хамгийн сүүлд панелистүүдийг урьж, харилцан хэлэлцүүлэг өрнүүлж байвал илүү үр дүнтэй байх болов уу гэсэн саналыг хэлмээр байна. Ингээд үгээ төгсгөө. Та бүхний ажилд их амжилт хүсье. Өнөөдрийн хурлыг маш сайхан зохион байгуулсан багш нартаа, Монголын япон хэлний багш нарын холбоондоо, мөн Монгол-Япон төвийн хамт олонд баяр хүргэж, талархсанаа илэрхийлье. Илтгэгч нартаа баярлалаа.

